

Олон хороодын Төлөөлөгчдийн хуралдаан

1924-4-7-нд нийслэл хүрээнд хотын түр захиргаа байгуулсан тухай бичигт түр захиргаа байгуулахын тулд олон хороодын төлөөлөгчдийг хуралдуулан түүнээс төлөөлөгч сонгуулан энэ оны 4-р сарын 9-нд дотоод яамнаас төлөөлөгчдийн анхдугаар хурал хийлгэж, түр захиргааны дүрэм ёсоор эрхлэн гүйцэтгэх үүргийг үүсгэн ярилцаж, журамлан явуулах учрыг тушаасан тухай дурдаад Комиссын гишүүд

Жигмэддорж

Сүндэвдорж

Буяндэлгэр

Магсаржав

Дугаржав гэжээ.

1925 онд Улаанбаатар хотын жинхэнэ захиргааг хотын ард олны ардчилсан сонгуулийн үндсэн дээр байгуулсан.

1925-12-11-нд Улсын 2 дугаар их хурлаар хотын захиргааны дүрэм дөчин есөн зүйлийг баталсан байна. Хотын захиргааны гүйцэтгэх газар нь долоон тэргүүлэгчидтэй, түүний дарга, орлогч, нарийн бичгийн дарга нар нь товчоо болон бүрэлдэж байсан

1930-11-14-нд Засгийн газрын 38-р тогтоолын 2-р зүйлээр олон аймаг, хот, сумдын дүрмийг шинэчлэн зохиож ирснийг зөвшөөрч улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраар батлуулахаар тогтоожээ.

1930 оны 11-р сард Засгийн газраас Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн

1930 онд аймгийн яамыг аймгийн захиргаа гэж нэрлэх болсон ба 1932 оноос дахин аймгийн яам гэж нэрлэжээ.

1931-2-26-нд Засгийн газрын эрхлэх товчооны 10-р хурлын 5-р зүйлээр орон нутгийн захиргааг шинэчлэн өөрчлөх хувьсгалт түр хороодыг түр хороо гэж нэрлэхээр тогтоожээ. 1931 оны 2 дугаар сард нутаг дэвсгэр засаг захиргааны хуваарилалт явуулах “түр хороод” аймгуудад байгуулагдсан ба мөн 3 дугаар сард сумдад “түр захиргаа” байгуулсан. Мөн 3,4 дүгээр сард хуучин аймгийн яам, хошуудын тамгын газрын татан буулгаж, шинэ байгуулагдсан сум, аймгийн ардын төлөөлөгчдийн 1 дүгээр их хурал хуралдаж, тариалан зэрэг 13 аймаг байгуулагджээ.

1937-2-5нд Сайд нарын Зөвлөлийн 2-р хурлын 2-р зүйлээр Улаанбаатар хотын захиргааны нэрийг өөрчилж нийслэл Улаанбаатар хотыг захирах яам гэж нэрлэжээ.

Улаанбаатар хотын байдлыг шинэчлэн сайжруулах комиссын даргаар Дэмидыг томилсон байна.

-Хороодын захиргааны эрүүл иргэний хэргийг таслан шийтгэхийг

-Хот сайжруулах засах ерөнхий төлөвлөгөөг баталжээ.

1952-12-27-нд Сайд нарын Зөвлөлийн 452-р тогтоолоор аймаг, хот, сум, хороодын АДХ ба тэдгээрийн гүйцэтгэх захиргаадаас заавал биелүүлэх шийдвэр гаргах тухай, түүнийг зөрчвөл захиргааны шугамаар арга хэмжээ авч байх тухай дүрмийг баталжээ.

1961-6-20-нд Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 136-р зарлигаар 3000-ас доошгүй байнга оршин суух хүн амтай аж үйлдвэрийн төв газрууд -4000-аас доошгүй байнга оршин суух

хүн амтай засаг захиргаа аж ахуй, соёлын төв суурин газруудыг хот болгож байхаар тогтоосон байна.